

БАТЛАВ

ЗАСАГ ДАРГА М.БОЛДБААТАР

ТАЙШИР СУМД "МАЛ УГААЛГЫН ВАНН БАРИХ" АЖЛЫН ДААЛГАВАР

2024.03.06.

Цагаан-Олом

1. Ажлын тодорхойлолт

1.1. Тайшир сумын Далан багт "Мал угаалгын ванн барих" ажлын даалгавар

№	Ажлын нэр	Мал угаалгын ванн барих
1	Төсөл хэрэгжүүлэх ундэслэл	Сумын Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрт заасны дагуу
2	Захиалагч байгууллага	Говь-Алтай аймгийн Тайшир сум ЗДТГ
3	Мал угаалгын ванн барих талбайн байршил	Монгол улс: Баруун бүс. Говь-Алтай аймаг, Тайшир сум <i>Далан бар</i>
4	Техникийн тодорхойлолт	<ul style="list-style-type: none"><li>➤ Ванны тавцангийн багтаамж нэг удаа 20-25 бог мал байна.</li><li>➤ Угаалгын ванн, хоолой хэсэг бетон арматурын бүтэцтэй байна.</li><li>➤ Ванны өндөр 1,8-2,0 м</li><li>➤ Ванны ханын зузаан 30см, бетон ул нь 20см-ээс багагүй зузаан бетоноор хийх</li><li>➤ Хоолой хэсгийн хүзүүний урт 6,0 м угаалгын ванны суурь хэсгээс эхлэх хоолой хэсгийн өргөн нь 1,8 м амсах хэсгийн өргөн 1,0 м байх</li><li>➤ Гарах хэсгийн хашааны өндөр 1,3 м-ээс багагүй хэмжээтэй байх</li></ul>
5	Мал угаалгын ванни баримталвал зохих стандарт	<ul style="list-style-type: none"><li>➤ Орох хэсгийн хашааг олдоц бүхий материалыг /mod, чулуу, төмөр/ ашиглан 300-аас доошгүй тооны бог мал орох багтаамжтай, 1,3м-ээс багагүй өндөртэй цоожтой хаалга бүхий бат бөх хашаа байна. Хашаа нь суурин болон зөөврийн хашаа байж болно.</li><li>➤ <b>Үдээвч хашаа</b> Орох хэсгийн хашаатай залгаж угаалгын ванни байгууламжтай холбосон 1,3м өндөр, 2,4м өргөн, 3,0 м урттай, 2 талдаа хаалгатай, 2 тал хашаа байна. Орох хэсгийн хашаатай талын хаалга нэг талруугаа нээгдэж, хаагддаг байна. Угаалгын ванн талын хаалга гүйдэг, цоожлогчтой хаалга байна. Уг хашааны шалыг бүрэн бетондож хийнэ.</li><li>➤ Угаалгын ванн нь газрын гүн рүү 1,8-2,0м гүнэгийн ухаж ханийг төмөр бетон арматур бүтцийн угсралттай суурин бетон цутгамал бүтээцтэй 2,4 м өргөн 3,5 м урт трапец хэлбэрийн байгууламж</li><li>➤ Ванны төмөр тавцан хоер талруу нээгдэж, нийлдэг рольктой болон доошоо буудаг 2 янз байна. Төмөр тавцангийн урт</li></ul>

		<p>2,0м өргөн 2,4 м байна. Угаалгын ванны дээд талд 1,3 м өндөртэй 3 тал хашаатай байна. 3 талт хашааны шонг бетоноор бат бех цутгаж суулгаж өгнө. Төмөр тавцанг дуу чимээ гарах, мал халтирахаас хамгаалж резинен жийргэвч наана.</p> <ul style="list-style-type: none"> <li>➤ Угаалгын ванны ханын зузаан 30 см бетон ул нь 20 см-ээс багагүй зузаан байна.</li> <li>➤ Угаалгын онгоцны багтаамж 6,8-7 тонноос багагүй</li> <li>➤ <b>Хоолой хэсэг</b> Угаалгын ванны суурийн түвшнээс 6м урт үргэлжилсэн 0,27 градус налуу өгсүүр, 1м өргөн хоолой нь угаагдсан мал налуу замаар ажлын уусмалыг биеэс шавхаж, гарах хэсгийн налуу талбайд шилжих хэсэг</li> <li>➤ Хоолой хэсгийн хоёр талаарх хашааны өндөр 1,3 м-ээс багагүй байх</li> <li>➤ <b>Гарах хэсэг</b> Угаалгын ваннаас мал хоолой хэсгээр дамжин уусмалыг биеэс шавхаж зогсох налуу талбай нь 10-15м<sup>2</sup> хэмжээтэй бетондсон байна. Налуу талбай нь 1,3м-ээс багагүй өндөртэй цоож бүхий хашаа байна. Бетондсон талбайн гадаргуу 10см-ээс доошгүй зузаантай байна.</li> <li>➤ <b>Ашигласан уусмал хийх худаг</b> Угаалгын ваннаас 10-15м-ийн зайд мал угаасны дараах ашигласан уусмалыг зайлцуулах нүх байна. Ажилласан ажлын уусмалыг зайлцуулах нүхэнд хийсний дараа эмийн бодис үйлдвэрлэгчийн зааврын дагуу саармагжуулна. Ашигласан ажлын уусмалын зайлцуулах нүхний урт 3,0м өргөн 2,0 гүний өндөр 2,5 м /эзэлхүүн 15 тонн/ байхаар газрын хөрсийг ухаж хийнэ. Нүхний дотор талын ханын шире нурахаас хамгаалж 5см-ын банзаар доторлож, дээд талыг таглаж битүүлнэ. Анхааруулах тэмдэг байна.</li> </ul>
6	<u>Иж бурдэл</u>	<ul style="list-style-type: none"> <li>➤ Мал угаалгын ванн шинээр барих</li> <li>➤ Хашаа хийх</li> </ul>
7	Захиалагчийн нэр, хаяг, утас	Говь-Алтай аймгийн Тайшир сумын ЗДТГазар